



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 17 өдөр


Дугаар 103

Мандалговь

Тэргүүлэх чиглэл батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 60 дугаар зүйлийн 60.1.8, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А-361 дугаар тушаалаар баталсан Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журамын 3.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дундговь аймгийн "Хоршоо хөгжүүлэх сан"-гийн тэргүүлэх чиглэлийг хавсралтаар баталсугай.
2. Тэргүүлэх чиглэлийн жилийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр гарган аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст ирүүлж байхыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.
3. Тэргүүлэх чиглэлийн хэрэгжилтэд хяналт тавьж, тайланг жил бүрийн 12 дугаар сард багтаан аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж ажиллахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Н.Эрдэнэ-Очир)-т даалгасугай.



4822100244

Аймгийн Засаг даргын 2022 оны
03 дугаар сарын 17-ны өдрийн 03
дугаар захирамжийн хавсралт

“ХОРШОО ХӨГЖҮҮЛЭХ САН”-ГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

№	Эдийн засгийн салбар	Чиглэл
1	Хүнсний үйлдвэр	<ul style="list-style-type: none"> - Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл - Талх, нарийн боов гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэл - Малын дайвар бүтээгдэхүүн боловсруулах, худалдаалах - Хоол үйлдвэрлэл
2	Хөнгөн үйлдвэр	<ul style="list-style-type: none"> - Төмөр эдлэл үйлдвэрлэл - Оёдол эсгүүр үйлдвэрлэл - Гутал үйлдвэрлэл - Модон эдлэл /мужаан, гэрийн тавилга/ - Сүлжмэл, нэхмэл ноос ноолууран эдлэл - Хог хаягдал ангилан ялгалт, дахин боловсруулах
3	Газар тариалан	<ul style="list-style-type: none"> - Төмс, хүнсний ногоо - Мод, Жимс жимсгэнэ тариалах - Хүлээмжийн аж ахуй - Тэжээлийн ургамал тариалалт
4	Мал аж ахуй	<ul style="list-style-type: none"> - Арьс, шир боловсруулах - Эсгий эдлэл - Мал үржлийн ажил үйлчилгээ - Мал эмнэлэгийн ажил үйлчилгээ - Гахай, шувууны туслах аж ахуй
5	Барилга	<ul style="list-style-type: none"> - Блок, тоосго, замын өнгөт хавтан үйлдвэрлэл - Зөөврийн сууц, төмөр хашаа, хийц
6	Үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> - Үсчин, гоо сайхан манекюр - Авта засвар, дугуй засвар - Гагнуур - Гутал засварын үйлчилгээ - Зочид буудлын үйлчилгээ - Аялал жуулчлал